



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/69

Алтанбулаг

Мал амьтны гоц халдварт үхрийн
арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.12, Сэлэнгэ аймгийн Онцгой комиссын 2022 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 05 тоот хуралдааны тэмдэглэл, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/176 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг уг өвчинд мэдрэмтгий мал сүрэгт 2022 оны 05 дугаар сарын 13-ний өдрөөс 10 хоногийн хугацаанд шуурхай, чанартай зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, шаардлагатай шатахууны зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар, дархлаажуулалтын замын маршрутыг 3 дугаар хавсралтаар, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодис бусад материалын тооцоог 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтын үйл ажиллагааг батлагдсан хуваарийн дагуу, технологийн хугацаанд нь шуурхай, чанартай зохион байгуулж, тайлан мэдээж хүргүүлэн хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Х.Отгонжаргал)-д даалгасугай.

4. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийг малын хөлийн татварын орлогоор санхүүжилт хийх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан шийдвэрлүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан (Р.Насанжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ